



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 0/93

Улаанбаатар хот

Орон нутгийн хөгжлийн сангийн
хөрөнгөөр 2017 онд дамжин хэрэгжих ажлын
жагсаалтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.4 дэх заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 3/13 дугаар тогтоол, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны А/118, 2017 оны А/83 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2017 онд дамжин хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтад оруулах өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.
2. Хөрөнгө оруулалтын ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Ж.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын дэргэдэх Санхүү, эдийн засгийн ажлын хороо /Э.Батболд/-д даалгасугай.



Б.МӨНХЦЭЦЭГ

1180000276

Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн
2017 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн
0742 дугаар тогтоолын хавсралт



Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2017 онд
хийгдэх ажлын жагсаалтад оруулах өөрчлөлт

Д/д	Оруулах өөрчлөлт
1	Автомашинны гарц гаргаж тохижуулах, байршил Цагдаагийн 1 дүгээр хэлтэс, төсөвт өртөг 15.0 сая гэснийг хасах
2	Дулааны нэгдсэн шугам сүлжээнд холбох, байршил 12 дугаар хорооны цогцолбор байр, төсөвт өртөг 25.0 сая гэснийг хасах
3	Шугам, хоолойн засвар, шинэчлэл, байршил 20-р хороо ХЦХ-ны дан байр, төсөвт өртөг 50.0 сая гэснийг хасах
4	Камержуулалт, автомашины хаалт суурилуулах, байршил Дүүргийн Тамгын газрын байр, төсөвт өртөг 15.3 сая гэж шинээр нэмэх
5	Дээврийн засвар, байршил 24 дүгээр хорооны цогцолбор байр, төсөвт өртөг 7.5 сая гэж шинээр нэмэх
6	Дээврийн засвар, байршил 15 дугаар хорооны цогцолбор байр, төсөвт өртөг 7.8 сая гэж шинээр нэмэх
7	Халуун, хүйтэн усны шугамын засвар, байршил 27 дугаар хорооны цогцолбор байр, төсөвт өртөг 9.4 сая гэж шинээр нэмэх
8	Тоног төхөөрөмжийн шинэчлэл, байршил 6 дугаар хороо, төсөвт өртөг 3.0 сая гэж нэмэх
9	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, байршил 19 дүгээр хороо, төсөвт өртөг 6.0 сая гэж нэмэх
10	Дотор засвар, байршил 24 дүгээр хорооны цогцолбор байрны нэг цэгийн үйлчилгээний танхим, төсөвт өртөг 1.0 сая гэж нэмэх
11	Дээврийн засвар, байршил Усан спорт сургалтын төв, төсөвт өртөг 40.0 сая гэж нэмэх